

Монголын Сумын ЭМЧ, мэргэжилтнүүдийн холбооны
Ерөнхийлөгчийн, 2025 оны 8 дугаар сарын 18-ны
өдрийн 18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Мэргэшлийн зэрэг горилогчийн тусгай шаардлага

Нэг. Хүний их эмч

1.1. АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.1.1. Сум, тосгон, багийн их эмч нь хүүхэд, дотор, эх барих, мэс засал болон бусад мэргэшлээр богино хугацааны болон баримжаа олгох сургалтад хамрагдсан байх /үнэмлэх, гэрчилгээ/;
- 1.1.2. Сум, тосгон, багийн их эмч нь ажилласан хугацаандаа дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран ажилдаа дүн шинжилгээ хийж 1-ээс доошгүй удаа илтгэл бичиж, хэвлэн нийтлүүлснийг байгууллагын удирдлага, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгээр баталгаажуулсан байх;
- 1.1.3. Сум, тосгон, багийн их эмч нь ажилласан жилдээ 3-аас дээш эмнэлгийн мэргэжилтэн, анагаахын чиглэлээр сурч буй оюутныг дагалдуулан, дадлагажуулсан байдлыг дагалдуулан сургасан тайлан, эмч, мэргэжилтний диплом, эмчлэх эрхийн гэрчилгээ, оюутны тайлангаар баталгаажуулсан байх;
- 1.1.4. Иргэдэд эрүүл зан үйлийг хэвшүүлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгааны материал 3-аас дээш боловсруулан хийж, сургалт, сурталчилгаанд ашигласан баримтыг хавсаргасан байх;
- 1.1.5. Эмнэлгийн эмч мэргэжилтэн нарт мэргэжлийн чиглэлээр сургалтыг 3-аас дээш удаа зохион байгуулсныг сургалтын удирдамж тайлангаар баталгаажуулсан байх;
- 1.1.6. Ажлын үзүүлэлт сүүлийн 3 жилээр гаргасан байх.

1.2. ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.2.1. Сум, тосгон, багийн их эмч нь хүүхэд, дотор, эх барих, мэс засал болон бусад мэргэшлээр мэргэшсэн /үнэмлэх, гэрчилгээ/ байх;
- 1.2.2. Сум, тосгоны их эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш 3-аас дээш удаа илтгэл бичиж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгд хэвлүүлэн баталгаажуулсан байх;
- 1.2.3. Сум, тосгон, багийн их эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш 3-аас дээш эмнэлгийн мэргэжилтэн, анагаахын чиглэлээр сурч буй оюутныг дагалдуулан, дадлагажуулсан байдлыг дагалдуулан сургасан эмч, мэргэжилтний диплом, эмчлэх эрхийн гэрчилгээ, оюутны тайлангаар баталгаажуулсан байх;
- 1.2.4. Ажилдаа шинэ санаа, сайн туршлага санаачлан, байгууллагын чанарын албаар баталгаажсан байх;
- 1.2.5. Иргэдэд эрүүл зан үйлийг хэвшүүлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 3-аас дээш хийснийг сургалтын удирдамж, тайланг хавсаргасан байх;
- 1.2.6. Эмнэлгийн эмч мэргэжилтэн нарт мэргэжлийн чиглэлээр сургалтыг 3-аас дээш удаа зохион байгуулсныг сургалтын удирдамж тайлангаар баталгаажуулсан байх;
- 1.2.7. Ажлын үзүүлэлт сүүлийн 3 жилээр гаргасан байх.

1.3. ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.3.1. Сум, тосгон, багийн их эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалнаас хойш хугацаанд Анаагаах ухааны магистр хамгаалсан, удирдлагын сургалтад хамрагдсан байх /үнэмлэх, дипломоор баталгаажуулах/;
- 1.3.2. 5-аас дээш эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтаар дагалдуулан сургаж, дадлагажуулсан дадлагажигчийн гэрчилгээ, тайланг хавсаргах;
- 1.3.3. Олон улсын, улсын, бүс нутгийн, орон нутгийн чанартай төсөл, судалгааны ажилд судлаач, гүйцэтгэгчээр 3-аас дээш удаа оролцсон байх;
- 1.3.4. Орон нутаг болон бүсийн хэмжээнд сургалт, зөвлөгөөнд асуудал дэвшүүлсэн илтгэл тавьж оролцсон байх;
- 1.3.5. Эмчилгээ үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн талаар шинэ санаа, санаачилга гарган ажилласан тэргүүн туршлага, бусдад туршлагаа хуваалцан нэвтрүүлсэн байдал тайлангаар баталгаажуулах.

Хоёр. Хүний бага эмч

2.1. АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.1.1. Ажилласан жилдээ 2-оос доошгүй удаа эрдэм шинжилгээ судалгааны ажилд дангаар болон бусадтай хамтран оролцсон нийтлүүлснийг байгууллагын удирдлага, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгээр баталгаажуулсан байх;
- 2.1.2. Ажиллах хугацаандаа иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлагыг 3-оос доошгүйг боловсруулсан байх /боловсруулсан санамж, зөвлөмжөөр баталгаажуулах/;
- 2.1.3. Сум багийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, өдөрлөгийг 2-оос доошгүй зохион байгуулж хийсэн байх /сургалтын удирдамж, тайлангаар баталгаажуулах/;
- 2.1.4. Хариуцсан сум, багийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг 2-оос дээш удаа авч, дүгнэн харьцуулсан байх;
- 2.1.5. Ажлын үзүүлэлт сүүлийн 3 жилээр гаргасан байх.

2.2. ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.2.1. Дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 3-аас доошгүй удаа илтгэл хэлэлцүүлэн ажилдаа дүн шинжилгээ хийж, хамт олноороо хэлэлцүүлснийг байгууллагын удирдлага, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгээр баталгаажуулсан байх;
- 2.2.2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлагыг 5-оос доошгүйг боловсруулсан байх /боловсруулсан санамж, зөвлөмжөөр баталгаажуулах/;
- 2.2.3. Сум багийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, өдөрлөгийг 3-оос доошгүй зохион байгуулж хийсэн байх /сургалтын удирдамж, тайлангаар баталгаажуулах/;
- 2.2.4. Мэргэжил нэгт болон бусад мэргэжилтнүүдэд 3-аас дээш удаа сургалт зохион байгуулах /удирдамж, тайлан/;
- 2.2.5. Хариуцсан сум, багийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг 4-оос дээш удаа авч, дүгнэн харьцуулсан байх;
- 2.2.6. Ажлын үзүүлэлт сүүлийн 3 жилээр гаргасан байх;

Гурав. Хүний их эмч, бага эмчийн

3.1. ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1. Дангаар болон бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 5-аас доошгүй удаа илтгэл хэлэлцүүлэн ажилдаа дүн шинжилгээ хийж, хамт олноороо хэлэлцүүлсэн байх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд дангаар болон бусадтай хамтран оролцсон байх;
- 3.1.2. Орон нутгийн хэмжээнд сургалт семинар зохион байгуулахад оролцон ажлаа танилцуулсан, бусдаас суралцсан, туршлагаа нэвтрүүлсэн байдал /тайлан/;
- 3.1.3. Мэргэжил нэгт болон бусад мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан /удирдамж, тайлан/;
- 3.1.4. Иргэдэд эрүүл мэндийн тусламжийн чиглэлээр шинэ санаа, оновчтой санал гарган нэвтрүүлсэн байдал /байгууллагын тодорхойлолт, гэрчилгээ/;
- 3.1.5. Шинээр төгссөн бага эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн 5-аас доошгүйг дагалдуулан сургаж туршлагажуулсан байх /тайлан/;
- 3.1.6. Үйлчлэх хүрээний сэтгэл ханамжийн судалгааг 6-оос дээш удаа авч, дүгнэн харьцуулсан байх;
- 3.1.7. Ажлын үзүүлэлт сүүлийн 3 жилээр гаргасан байх.

Дөрөв. Хүний их эмч, бага эмчийн ахлах, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтнүүдийн давтан хамгаалалтыг тайлан хамгаалалтаар тооцно:

4.1. Урьд нь хүний их эмч, бага эмчийн ахлах, тэргүүлэх зэрэг хамгаалсан мэргэжилтнүүд мэргэжил, мэргэшлээр тасралтгүй 10 жил ажилласан байх;

4.2. Хүний их эмч, бага эмчийн ахлах, тэргүүлэх зэргийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх.